



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/138

Цагаан-Уул сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга: У.Аварзэд (Засаг даргын орлогч)

Гишүүд: А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

З.Аззаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Л.Сэрсмаа (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн

дарга)

Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолт бэлтгэх, урилга хүргүүлэх, үнийн санал хүлээн авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид танилцуулж ажиллахыг үнэлгээний хороо (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-т даалгасугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/